

тусгай зураг, цэс бүхий нутаг юм. Суман харуулд хэдийгээр гэр харуул шиг том нутаг байхгүй боловч орших суух, алба, амины мал сүргээ адгуулах тодорхой хэмжээний газартай байжээ. Иймд хилийн харуулуудын суурьшин асан нутгийг улсын хил гэж үзэх нь түүхийн үнэнтэй зөрчилдөн улсын хилийн нутгаа тануулахад хүрч байгааг эрхиш анхаарч үзүүштэй.

Ном зохиол


1. А.Г.Банников. Первое русские путешествия в Монголию и Северную Китай. М., 1954
2. Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг. Өмнөд зохиол 9-р дэвтэр.
3. Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг. Жинхэнэ зохиол. 49-р дэвтэр.
4. И.М.Майский. Монголия накануне революции. М., 1960
5. В.В.Мойсеев. Цинская империя и народы Саяно-Алтай 18 в. М., 1983.
6. А.Очир Үнэнээр гул бариад хол явахгүй. Монголын залуучууд. 1991. № 34
7. О.Пүрэв. Эв модны наадам. Залгамжлагч. 1985 № 5
8. УТИС. Засагт хан аймгийн 20 засаг хошуу, 3 Хутагтын шавийн нутагласан газар орныг хураангуйлсан зураг.
9. Б.Цэдэн-Иш. Үнэнийг өгүүлнэм. Монголын залуучууд. 1991. № 14.

Дэд доктор Ж.Гэрэлбадрах

МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН ХИЛИЙН ЗҮҮН УУЛЗВАРЫН ЦЭГИЙГ ТОГТООЖ ТЭМДЭГЛЭСЭН НЬ

Монгол, Орос, Хятад улсын хилийн уулзваруудын хоёр цэгийн бодит байдлыг тодорхойлохын тулд Талуудын хамтарсан ажлын хэсэг байгуулахаар шийдэж гурван улсын хилийн Зүүн уулзварын тодорхойлолт-протоколд хавсаргах 1:100 000-ны масштабтай газрын зураг үйлдэн Зүүн уулзварын цэгт хилийн "Тарваган дах" тэмдэг босгож, уг хилийн тэмдгийн протокол үйлдэхийг тус тус хариуцуулжээ.

Гурван улсын хилийн Зүүн уулзварын цэгийн тухай Тодорхойлолт-протокол "... Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн Зүүн уулзварын цэг нь 645.0 тоот бүхий өндөрлөгт дээрх "Тарваган дах" овооны төвд оршино.



Энэ цэг нь Монгол, Оросын хилийн шугам дээрх хилийн 964 дүгээр тэмдгээс зүүн өмнө зүгт 759.7 метрт, орос, хятадын хилийн шугам дээрх 1 дүгээр тэмдгээс баруун хойд зүгт 147.8 метрт, монгол, хятадын хилийн шугам дээрх 639 дүгээр тэмдгээс зүүн хойдын хойд зүгт 8.7 метрт байна" гэж тэмдэглэжээ.

Гурван талын хамтарсан ажлын хэсэг гурван улсын хилийн Зүүн уулзварын цэгт Тарваган дахын овооны төвийн дээр "Тарваган дах" нэртэй "0" дугаартай хилийн тэмдэг босгосон ба энэхүү тэмдэг нь гурван талт боржин багана, металл тулгуурын хэсэг, төмөр бетон сууриас бүрддэг.

Тодорхойлолт-протоколын тавдугаар зүйлд уг тэмдгийг арчлан хамгаалах тухай заасан байдаг. Үүнд:

1.Тарваган дах тэмдгийг шилжүүлэн зөөх, эвдэх, алга болгох явдал гаргахгүй байхад чиглэгдсэн шаардлагатай арга хэмжээг гурван этгээд авна.

2.Аль нэг тал нь дангаараа уг тэмдгийн байршил, хэлбэр хэмжээг өөрчлөх буюу хилийн уулзварын цэгт хилийн шинэ тэмдэг тавих эрхгүй болохыг заасан.

3.Монголын болон Оросын тал Тарваган дахын тэмдгийн суурь, металл тулгуурыг арчлан хамгаална. Мөн засварлах үүрэг хүлээнэ. Харин хятадын тал уг тэмдгийн баганыг арчлан хамгаалах, засварлах үүрэг хүлээнэ гэж заасан байдаг.

4.Гурван тал уг хилийн тэмдгийг шилжүүлсэн, эвдсэн, алга болгосныг илрүүлсэн тохиолдолд нөгөө хоёр талдаа даруй мэдэгдэнэ. Энэ тэмдгийг протоколд заасан хэмжигдэхүүний дагуу хариуцагч талууд сэргээн босгох, засварлах ажлыг гүйцэтгэхдээ бүх талын төлөөлөгчдийг байлцуулж гүйцэтгэнэ.

5.Гурван тал шаардлагатай үед хилийн энэ тэмдгийг хамтран шалгаж байхаар тогтжээ. Харин шалгалт хийсэн, засварласан, сэргээн босгосон дүнгийн тухай хамтарсан протокол үйлдэж, төлөөлөгчид гарын үсэг зурсны дараа энэхүү тодорхойлолт-протоколд хавсаргадаг байна.

Тарваган дах хилийн тэмдгийн энэ протоколд 1996 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Бээжин хотод гурван улсын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурсан байна.

**Тарваган дахын овооны одоогийн байршлын талаар
зарим нэг эргэлзээ байдаг тухайд.**

Тарваган дахын овооны талаар түүхийн ухааны дэд доктор, дэслэгч генерал Б.Цэдэн-Иш 1979 оны 6 дугаар сарын 06-ны өдөр "Монгол-Зөвлөлт-Хятад гурван улсын хилийн уулзварын тухай" тодорхойлолт бичиж, Монгол, Зөвлөлтийн хооронд, мөн Монгол, Хятадын хооронд хил тогтоохдоо тус гурван улсын хилийн уулзварын талаар шийдвэрлэгдэж чадаагүй асуудалд зориулав гэж бичээд одоогийн Зүүн уулзварын цэг болох Тарваган дахын овоо мөн болох талаар өөрийн эргэлзээтэй зүйлээ бичсэн байдаг. Үүнд: "Орос, Манжийн хооронд Тагна Урианхай, Халх, Баргын нутгийн хойд этгээдээр 1727 оны 8 дугаар сарын 20-ны Буурын хилийн гэрээгээр тогтоогдсон хил ба Халх, Баргын хооронд 1822 он болон 1845 онд тогтоогдсон хилээр үзэхэд Монгол, Зөвлөлт, Хятад гурван улсын хилийн уулзвар нь Тарваган дахын овоонд байвал зохих байршил, хэм хэмжээ нь тохирохгүй байна" гээд учир байдал иймээс: "Монгол, Хятадын хилийн хэлэлцээ явуулах үед гурван улсын хилийн уулзварыг даруй хамтран тогтоох бололцоогүй байсан учир цаг алдахгүйн тулд хятадтай явуулах хилийн хэлэлцээнд одоогийн баримталж байгаа газрын зураг дээр тодорхойлогдсон гурван улсын хилийн уулзварыг хэвээр баримтлахаас өөр аргагүй байсан" гэжээ.

Хятадтай хилийн хэлэлцээр явуулахын өмнө монголын тал санал бодлоо Зөвлөлтийн талд урьдчилан танилцуулахаар Гадаад Харилцааны яамны чиглэлийн хэлтсээр дамжуулан Зөвлөлтийн Элчин Сайдын Яаманд тус гурван улсын хилийн уулзварыг дор дурдсан газар зүйн солбицлоор тодорхойлж мэдэгдсэн байна.

Үүнд:

Тарваган дах: Дорнод уртрагийн 116°42'50"

Хойд өргөргийн 49°50'40" –д байна гэжээ.

Монголын талаас энэ асуудалд хандахдаа Тарваган дахын овооны байршил нь тохирохгүй байгааг мэдсээр байсан атлаа тэр үеийн Монгол, Хятад, Орос, Хятадын хоорондын харилцаанд улс төрийн таагүй уур амьсгал үүсэж байсан цаг мөчид асуудлыг маргаангүйгээр шийдэхийн тулд газрын зурагт алдаатай тэмдэглэсэн Тарваган дахын овооны байршлыг тэр хэвээр нь хүлээн зөвшөөрсөн байдлаар дээрх саналыг оросын талд тодорхойлж өгсөн нь 1930-аад оны үед Оросын талаас үйлдсэн газрын зургийн алдааг хүлээн зөвшөөрсөн хэрэг учир

хариуд нь Зөвлөлтийн талаас дараахь хариултыг өгсөн байдаг. Энэ нь "Буурын хилийн гэрээний ёсоор санал зөрүүгүй тохирч байна" гэж харцуу мэдэгдсэн мэдэгдэл юм.

Монгол, Хятадын хилийн гэрээг боловсруулан бэлтгэж дуусаад Бээжинд гарын үсэг зурахын өмнө тэр өдөр Хятадын төлөөлөгчдөөс Тарваган дахын овоо өөр газарт байгааг Монголын талд сануулж байсныг Монголын талаас энэ гэрээг боловсруулах ажилд оролцсон хүмүүс өмнө нь Зөвлөлтийн талд уг овооны байршлыг алдаатай байршлаар нь хүлээн зөвшөөрч хариу саналыг авч санал нэгдсэндээ сандарч хилийн гэрээг маргаангүй хамтран боловсруулж нэгэнт дууссаны дараа ийм маргаантай асуудал авч хэлэлцэхээс татгалзсан ба монголын талын тэр үеийн төлөөлөгчид асуудлыг улс төржүүлж үзэхдээ Хятадын тал Монгол, Зөвлөлтийн найрамдлыг өдөөн хатгаж хилийн маргаантай асуудлыг Монголын талаас тавиулж мухардмал байдалд оруулах гэж байна гэж үзсэн байдаг.

Тэр үеийн байдлыг авч үзвэл :

1.Орос, Хятадын хооронд хилийн тухай асуудал бараг яригдаагүй байсан,

2.Монгол, Оросын хооронд Буурын гэрээний дагуу тогтоогдсон гэх хил хамгаалалтын хилийг баримталж, албан ёсны хилийн гэрээ, хэлэлцээр байгуулагдаагүй байсан үед Монгол, Хятадын хилийн гэрээг 1962 онд байгуулж 1963 онд улсын хилийг газар дээр нь тэмдэглэх /демаркац/ ажил явагдсан үе байлаа. Ийм үед хэдийгээр Монгол, Хятадын тал Тарваган дахын овооны байршлыг Оросын нутагт байгаад санал нэгдвэл хилийн гэрээ, хэлэлцээрүүд цаашид мухардмал байдалд орох байсан.

Монгол, Хятадын хооронд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх ажил 1963 онд явагдах үед Тарваган дахын овооны дэргэд 639 дүгээр тэмдгийг босгох ажил нэлээд хугацаагаар саатсан нь уг овоо байгаа 645.0 тоот дээр дээрх хилийн тэмдгийг босгох тухай асуудал байсан боловч Орос, Хятадын хилийн төлөөлөгчийн уулзалтаар энэ асуудал зөвшөөрөгдөөгүй байна. Хилийн 639 дүгээр тэмдгийг босгох ажилд оролцож явсан ахмад хилчин хошууч Лхагва-Очир гуайн дурсамж ярианаас ишлэл болгоход "... Би 639 дүгээр тэмдгийг босгох ажилд монголын талын ажлын хэсгийг ахалж байсан. 1963 оны намар их л орой бараг намрын сүүл сар гарч байсан /архивт он сартайгаа материал нь байгаа биз/ тэр нэг өдөр монгол, хятадын хил тогтоох техник ажлын хэсэг 639 дүгээр тэмдгийн баганыг босгохоор

Тарваган дахын овоон дээр ирэхэд Оросын талаас бүхээгтэй гурван ГАЗ-53 машинтай цэргүүд уг овоон дээр дөхөн ирж нэгэн орос хошууч бууж ирээд Хятадын талын ажлын хэсэгт ажиллаж айсан өвөрмонгол хүнтэй орос хэлээр чанга чанга ярилцан маргалдаж байхад уг өвөрмонгол хэлмэрч гараараа хойд зүг рүү байн байн зааж байсныг бодоход Тарваган дахын овооны байршлын тухай асуудлаар маргаж байсан байх гэж боддог. Тэр өвөрмонгол оростой ярьсан зүйлээ бидэнд танилцуулаагүй юм. Бид 639 дүгээр тэмдгийг ингэж л 3 машин орос цэргийн хяналт, хамгаалалтын дор босгож билээ" гэж ярьжээ.

Монгол, Зөвлөлтийн хооронд 1976 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Москва хотноо гарын үсэг зурсан хилийн гэрээний дагуу 1977-1979 онд хилийн шугамыг газар дээр нь тогтоон тэмдэглэх /демаркаци/ ажил явагдахад Монголын тал Монгол, Оросын хилийн одоогийн 964 шинээр /1310/ дугаар тэмдгийг Тарваган дахын 645.0 тоотод байгаа Тарваган дахын овооны дэргэд босгох саналыг тавьсан боловч Оросын тал татгалзаж уг овооноос 759.7 метр зайтай босгох санал тавьж манайхаар зөвшөөрүүлжээ.

Яагаад оросууд Тарваган дахын овооны дэргэд хилийн тэмдэг босгохоос болгоомжилсон бэ? гэдэг асуулт гарч ирж байна. Үүнд таамаглал дэвшүүлэхэд:

1. Хэдийгээр Тарваган дахын овооны байршлын талаар алдаатай газрын зураг гаргасныгаа Монголын талаар хүлээн зөвшөөрүүлсэн боловч Орос, Хятадын хооронд хилийн гэрээ байгуулагдах, улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх ажил явагдах үед уг овооны байршлын талаар Хятадын талаас асуудал сөхөгдөж гарч ирж болзошгүй гэж үзсэн.

2. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн уулзварын цэгийг тодорхойлох тухай асуудал бол гурван талын ашиг сонирхлыг хөндсөн тул үүнийг эрт, орой хэзээ нэгэн цагт хэлэлцэх үед гарч болох маргаантай асуудал гэж үзсэн учир Тарваган дахын овооны дэргэд хилийн тэмдэг босгохоос татгалзсан байж болох юм.

Тарваган дахын овооны уг байршлыг судалж үзвэл гурван улсын хилийн одоогийн тогтоосон уулзварын 645.0 тоот цэгээс хойд зүгт 7.2 км орчимд Оросын нутагт байгаа нь Хаант Оросын засгийн үеийн 1894 оны газрын зургаас үзүүлсэн байдал, Монголын хилийн харуулын /хуучин Зах хөвөлзөхийн харуулаас Тарваган дахын овоо хүртэл/ хилийн шугамаа цэвэрлэж, явдаг зам, түүний шуудуу газар

дээрээ мэдрэгдэж байгаагаас тодорхой байдаг.

Тарваган дахын овооны байршил нь яагаад өөрчлөгдсөн шалтгааныг дараахь байдлаар таамаглал дэвшүүлж болох юм. Үүнд:

1.1930-аад оны эхээр Японы милитаристууд Зүүн хойд Хятадыг эзлэн улмаар ЗХУ, Монгол Улсын хилд тулж ирээд байсан энэ үед Оросын тал цэргийн газрын зураг яаравчлан үйлдэж Тарваган дахын овооны жинхэнэ байршлыг өөрчилж урагшлуулсан байж болох ба уг овооны жинхэнэ байршил нь хориглох байлдаан явуулахад чухал ашигтай өндөрлөг байсан учир энэ хэсэгт хориглолтын инженерийн ажил явагдах үед сүйтгэгдсэн байж болох талтай юм. Одоо уг хориглолтын инженерийн байгууламжийн суваг шуудуу газар орон дээрээ мэдэгдэж байдаг.

2. Тарваган дахын овоо нь хоорондоо 5 м зайтайгаар босгосон том хэмжээний хос овоо байгаа тухай гэрээнд бичигдсэн байдаг. 1727 оноос хойш 250-иад жилийн дараа уг овоо хөрсжиж газаршсан байж бусад овооны ижил байх ёстой боловч одоогийн Тарваган дахын овоо нь дан чулуун шинэвтэр овоо юм. Чулууны зарим хэсэг нь бичигтэй ба нэг чулуун дээр "1937 г. Коммун" гэж бичсэн байдаг. Энэ нь 1858 оны Тяньжиний гэрээгээр болон 1860 оны Бээжингийн гэрээгээр Эргүнэ мөрний өмнө эргээр хил тогтоох үеэр Тарваган дахын овооны байршлыг өөрчилсөн байж болзошгүй гэсэн нэгэн таамаглалыг ч дэвшүүлдэг юм.

1992 онд Монгол, Оросын хилийг хамтран шалгах Монголын хэсгийн даргаар ажиллаж байсан НАХЯ-ны сайд агсан дэслэгч генерал А.Жамсранжав, хэсгийн орлогч даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Г.Хүүжий нар Бээжин хотод очиж гурван улсын хилийн уулзварыг тогтоох тухай санал тавихаар БНХАУ-д байхдаа албан бус ярианы үед Г.Хүүжий "Тарваган дахын овооны байршлын талаар эргэлзээтэй зүйл байдаг тухай" Хятадын талаас асуухад: Хятадын талын тэргүүн нь "Тарваган дахын овоо бол одоогийн 645.0 тоот өндөрлөг дээр байгаагаар тооцогдож олон улсын гэрээ, хэлэлцээрт олонтаа баталгаажиж дурдагдсан байдаг тул бидний хооронд энэ тухай асуудал байхгүй" гэсэн хариу өгчээ. Энэ нь Орос, Хятадын хооронд хилийн гэрээ байгуулагдахад хилийн шугамын дорнод хэсгийн эхлэлийг Тарваган дахын овооноос эхлэх тухай яригдах үед Тарваган дахын овоо нь 645.0 тоот өндөрлөг дээр байгаагаар маргаангүй тохиролцсон нь илт байна.

Тарваган дахын овооны одоогийн байршлын талаар зарим нэг

хэлэлцээрээр хүлээн зөвшөөрөгдөж тогтоогдсон хилийг дахин авч хэлэлцэх, хөндөх тухай санаа байхгүй бөгөөд ганцхан хилийнхээ овоонуудыг арчилж хамгаалж байгаагүй, тодорхой судалгаагүй байснаас бага ч гэсэн газар нутаг алдсанд харамслаа илэрхийлж, хил тогтоох ажилд оролцсон хүмүүст гавьяа байвч тэр цаг үеийн байдалд хүчин мөхөсдөж тэмцэл хийх боломжгүй байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Тарваган дахын овооны байршлын талаар цаашид сонирхсон хүмүүс судалгаа шинжилгээний ажил явуулахдаа миний дээрх зарим таамаглалыг нотлох, эсвэл няцаах талаас нь ул суурьтай авч үзэхийг үсэж энэхүү зүйлийг толилуулж байна.



ХЦДС-ийн ШНА-ны тэнхимийн ахлах багш,
дэд хурандаа Д.Шаравшагдар.